



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 44,566,500.00 (дөчин дөрвөн сая таван зуун жаран зургаан мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ж.Хичээнгүй, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА





Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн  
... дүгээр тогтоолын хавсралт

**"Төрийн орон сууцны корпораци" төрийн ёмчит үйлдвэрийн газарт шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

**"Автотээврийн Ундэсний төв" төрийн ёмчит үйлдвэрийн газарт шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Нийт гүйлт	Балансын дүн (төгрөгөөр)	Хууримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл ертөг (төгрөгөөр)
1	Ниссан Максима Маркийн сүүдлын автомашин, 00-06 УНЧ Улсын дугаартай, Арлын дугаар-1N4BA41E87C813835	2007	1	31977	44,566,500.00	44,566,500.00	0.00
					44,566,500.00		0.00
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		1 (нэг)		<b>44,566,500.00 (дөчин дөрвөн сая таван зуун жаран зураган мянга таван зуун)</b>	<b>44,566,500.00 (дөчин дөрвөн сая таван зуун жаран зураган мянга таван зуун)</b>	